



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах”
өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/448 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүрэгт “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр “Монгол хүүхдүүд” сэдвийн дор зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Баярын арга хэмжээнд зарцуулагдах 2,774,500 (Хоёр сая долоон зуун далан дөрвөн мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хуваарийн дагуу чанартай зохион байгуулахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны ...05... дүгээр сарын 24... ны өдрийн
А/10.6. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-ИЙН
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Болормаа

Засаг даргын Эдийн засаг, нийгмийн
хөгжлийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд:

Л.Санжийжамц
Д.Эрдэнэтуяа

Засаг даргын Тамгын газрын дарга
Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Зохион байгуулалтын хэлтсийн дарга

Б.Отгонжаргал

Төрийн захиргааны, удирдлагын
хэлтсийн дарга

Ц.Мягмарсүрэн

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга

Б.Цогжавхлан
Д.Хүрэлбаатар

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

Н.Нямзав
Б.Батзориг
Ш.Баасансүрэн
Б.Алтанцоож
Д.Энхтайван

1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга
Боловсролын хэлтсийн дарга
Соёлын ордны захирал
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга

Х.Ганбат
Б.Лхагвасүрэн

Эрүүл мэндийн төвийн дарга
Багахангай дүүрэг дэх Цагдаагийн
хэлтсийн дарга, хурандаа

Б.Цогбадрах

Онцгой байдлын хэлтсийн дарга,
хурандаа

Г.Тэмүүлэн

Биеийн тамир спортын хорооны
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Э.Соёмбобат

“Хангай” цогцолбор сургуулийн
захирал

Н.Тунгалаг
С.Отгонтуяа
Б.Гэрэлмаа

44 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
207 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
“Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын
дарга

Ч.Батхуяг

Багахангай гэрэлтүүлэг ногоон
байгууламж ОНӨААТҮГ-ын дарга

М.Өсөхдэлгэр


Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг
дэмжих төвийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Оюунгэрэл

Гэр бүл, хүүхэд залуучуудын
хөгжлийн хэлтсийн дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
 2023 оны 05 дүгээр сарын 04 ны өдрийн
 А/1106 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт




**“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-ИЙН
 АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран зохион байгуулах
Угтаж зохион байгуулах ажил				
1	“Хүүхдийн эрхийг хамгаалах сар” уриан дор Гэр бүлийн өдрийн арга хэмжээг зохион байгуулах	2023.05.01- 2023.05.30	ГБХЗХХ	ААНБ-ын эцэг эхийн зөвлөл
	“Хүүхдээ сонсох өдөр” арга хэмжээг зохион байгуулах	2023.05.04	ГБХЗХХ	ХӨУБ-ууд
2	“Хүүхдийн баярыг хэрхэн тэмдэглэх вэ” цахим санал асуулгыг хүүхэд багачуудаас авч нэгтгэх	2023.05.10- 2023.05.15	ГБХЗХХ	ХЦС
3	Ажлын хэсгийн хурал зохион байгуулах	2023.05.17	ЗДТГ	Ажлын хэсэг
4	Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан зохион байгуулах арга хэмжээний захирамж, төлөвлөгөө гаргах	2023.05.20	ЗДТГ ГБХЗХХ Хороод	ААНБ-ууд
5	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, мэдээлэл иргэдэд хүргэх	2023.05.20- 2023.06.01	ЭМТөв	Хороод ААНБ-ууд
6	Анонсын эх бэлтгэх, хэвлүүлэх	2023.05.25	НХХ	ЗДТГ
7	Төв талбайн нэгдсэн зураглал, схем гаргах	2023.05.28	ТХҮХ	Ажлын хэсэг
8	Арга хэмжээний бичлэг хийх, зураг авах, вэб сайт болон пэйж хуудаст мэдээлэл байршуулах	2023.05.28- 2023.06.01	ТЗУХ	Хороод
9	ААНБ-уудад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар мэдээлэл өгөх	2023.05.30	ГБХЗХХ	ААНБ-ууд
10	Нээлтийн арга хэмжээний хөтөлбөр гаргах	2023.05.30- 2023.06.01	ГБХЗХХ	Ажлын хэсэг

11	Цэвэрлэгээ үйлчилгээ хийх, хогийн сав байрлуулах, тусгаарласан тууз /хэлтэй/ татах	2023.05.31- 2023.06.01	Багахангай тохижилт ОНӨААТҮГ	-
12	Монгол ахуй бүрдүүлсэн гэр, 2 ногоон асар барих	2023.05.31	ЗДТГ	Цэргийн штаб
13	Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхэд багачуудыг “Монгол хувцасаар гоёх” уриалга гаргах	2023.05.25- 2023.06.01	Боловсролын байгууллагууд	-
06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулах ажил, арга хэмжээ				
1	Анонс тогтоох, тайз чимэглэх	2023.06.01	1-р хороо ГБХЗХХ	Төв талбайд
2	Тайз руу тог татах, урт разетик бэлтгэх	2023.06.01	“Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж” ОНӨААТҮГ	
3	Сургуулийн ногоон хивсийг тайзны өмнө дэвсэх, буцааж хүргэх	2023.06.01	Багахангай тохижилт ” ОНӨААТҮГ	
4	Урлагийн тоглолт, хөтлөгч, микрофон уэль, бусад шаардлагатай хөгжим техник хэрэгсэл, тайзны улаан хивс бэлдэх	2023.06.01	Соёлын ордон	
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд гарын бэлэг гардуулах	2023.06.01	ХХҮХ	
6	Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын нэрэмжит тэмцээн зохион байгуулах	2023.06.01	Хороод ААНБ-ууд	
7	Монгол уламжлалт бүжгийн Флаш моб зохион байгуулах	2023.06.01	ГБХЗХХ	Төв талбайд
8	Авто замын хөдөлгөөний зохицуулалт хийх, хяналт тавих, хамгаалалт гаргах	2023.06.01	Цагдаагийн хэлтэс	
9	“Монгол бүтээл” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	2023.06.01	ЖДҮДТ	Төв талбайд
10	Тоглоом, худалдаа, хоолны үйлчилгээ зохион байгуулах	2023.06.01	ТХҮХ Худалдаа үйлчилгээний байгууллагууд	Төв талбайд
11	Мотор бэлтгэх	2023.06.01	ОБХ	Тайзны ард

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 08 дүгээр сарын 04 ны өдрийн
А/10.6 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-ИЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1	Анонс	2.8x9	м ²	25,2	25,000	630,000
		1,5x2	м ²	3	25,000	75,000
2	Бэлэг	ш	64	25,000	1,600,000	
3	Шаар	боодол	5	20,000	100,000	
5	Малгай	ш	20	10,000	200,000	
6	Түлш (Нээлтэд 2-р хорооноос хүүхэд зөөх)	л	50	3390	169,500	
Нийт дүн:					2,774,500	